

## **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ СУРГАЛТ**

Компанийн хууль, компанийн засаглалын зарчмуудыг хуулийн дагуу хэрэгжүүлэх асуудал, Компанийн засаглалын үндсэн ойлголтууд, ТУЗ-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын харилцаа, Компанийн ТУЗ-ийн өмнө тавигддаг санхүүгийн буюу стратегийн үндсэн асуудлууд

### **ОРОЛЦОГСОД:**

Тус сургалтанд компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд, захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн дээд түвшний удирдлага, мэргэжлийн хүмүүс хамрагдана

### **СУРГАЛТАНД ХАМРАГДСАНААР ТА:**

- ❖ Компанийн хууль эрхзүйн орчин
- ❖ Компанийн засаглалын үндсэн ойлголтууд
- ❖ ТУЗ-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт
- ❖ ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын харилцаа

Компанийн ТУЗ-ийн өмнө тавигддаг стратеги болон санхүүгийн үндсэн асуудлуудыг судлан суралцах болно.

***Сургалтын гарын авлага болон ном, компанийн засаглалын чиглэлээр 1 жилийн хугацаанд анхан шатны зөвлөгөөг үнэгүй авах эрх олгогдоно.***

### **СУРГАЛТЫН БҮТЭЦ:**

Сургалт 3 үндсэн модуль 5 сэдвээс бүрдэх бөгөөд 1.5 өдөр үргэлжилнэ. Сургалт интерактив байдлаар оролцогчдын асуулт хариулт, кейс сургалт, харилцан бие биенийхээ туршлагаас суралцах боломжийг дэмжих аргаар явагдана.

### **БАГШ НАР:**

Бүх багш нар нь олон улсын түвшинд бэлтгэгдсэн Монголын цорын ганц байгууллага болох Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн сургагч багш нар хөтлөн явуулна.

**СУРГАЛТЫН ТӨЛБӨР:** 300 000₮ (CGDC-ийн гишүүн байгууллагууд 20% хөнгөлөлттэй)

Компани, аж ахуйн нэгжүүд өөрийн байгууллага дээрээ сургалт авах боломжтой (Төлбөрийн хөнгөлөлттэй байж болно). Төгсөгчдөд гэрчилгээ олгоно. Сургалтын төлбөрт холбогдох бүх зардлууд багтсан болно. Сурах бичиг, материал, танилцуулгаар бүрэн хангана.

### **ХОЛБОО БАРИХ:**

Утас: 7000 8084, 99105111, 88978179

Цахим шуудан: [info@cgdc.org.mn](mailto:info@cgdc.org.mn)

<b>Эхний өдөр</b>		
Сэдэв	Цаг	Агуулга
<p><b>Компанийн хууль</b></p> <p>Зорилго: Шинэчлэн батлагдсан компанийн хуулийн онцлог, түүнийг хэрэгжүүлэх асуудлаар ярилцах</p>	<p>10.00-11.40</p> <p>/2 цаг/</p>	<p>Компанийн хуульд орсон үндсэн өөрчлөлтүүд</p> <p>Компанийн сайн засаглалын асуудал, Компанийг үүсгэн байгуулахаас татан буулгах хүртэл эрх зүйн харилцаа, хуулийг хэрэгжүүлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлагын асуудал</p>
Цайны завсарлага	/10 мин/	
<p><b>Компанийн засаглалын үндэс:</b></p> <p>Зорилго: Компанийн Засаглалын ойлголт, ач холбогдлыг тайлбарлах</p>	<p>11.50-12.40</p> <p>/1 цаг/</p>	<p>Бизнес өмчлөлийн хэлбэрүүд, Өмчлөл ба удирдлагыг салгах нь, Эзэн ба удирдлагын асуудал, Түүх, Тодорхойлолт, Компанийн засаглалын зарчмууд, Онолын асуудлууд болон дэлхий дахины чиг хандлага; Олон улсын компанийн засаглалын бүтэц, Монголын компанийн засаглалын кодекс</p>
Өдрийн хоол	12.40-13.40	
<p><b>ТУЗ-ийн үйл ажиллагаа</b></p> <p>Зорилго: Компанийн засаглалын цөм болсон ТУЗ-ийн үйл ажиллагааг тайлбарлаж хэлэлцэх</p>	<p>13.40-15.20</p> <p>/2 цаг/</p>	<p>ТУЗ-ийн үүрэг роль, ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагаа</p> <p>Стратеги боловсруулалт ба хэтийн зорилго; Чиглүүлэх ба удирдахын ялгаа, ТУЗ-ийн Хороодын үйл ажиллагаа (Аудитын, Нөхөн олговрын, Нэр дэвшүүлэх). ТУЗ-ийн гишүүдийг сонгож томилох, ажлыг нь үнэлэх</p>
Цайны завсарлага	/10 мин/	
<p><b>ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын харилцаа</b></p> <p>Зорилго: ТУЗ-ийн чиглүүлэх үүрэг, гүйцэтгэх удирдлагын удирдах үүргүүдийн зааг, ялгаа, ТУЗ-аас гүйцэтгэх захирлыг сонгох, хянах, урамшуулах, чиглүүлэх арга замууд</p>	<p>15.30-16.40</p> <p>/1 цаг/</p>	<p>ТУЗ-ийн хяналт, гүйцэтгэх удирдлагын томилолт, гүйцэтгэлийн хэмжүүр, урамшуулал ба зөрчлийг шийдвэрлэх арга замуудыг авч үзэх</p>
<b>Дараагийн өдөр</b>		
<p><b>Гүйцэтгэх удирдлага</b></p> <p>Зорилго: ТУЗ-ийн стратеги боловсруулалт ба Гүйцэтгэх удирдлага</p>	<p>10.00-12.30</p> <p>/3 цаг/</p>	<p>Стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ТУЗ-ийн үүрэг, Гүйцэтгэх удирдлагатай харилцах харилцаа, Гүйцэтгэх удирдлагыг хянах, урамшуулах, манлайлах</p>